



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/501

Алтай хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Цээл сумын шинэ суурьшлын бүсэд инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | | |
|---------------------------|----------------|--|
| Үнэлгээний хорооны дарга: | Х.Баатарзориг | -(Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Гишүүд: | Б.Лхагва-Очир | -(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн) |
| | Ё.Нарангарав | -(Төрийн бус байгууллагын төлөөлөл) (тохиролцсоноор) |
| | Б.Галсанжамц | -(Есөнбулаг сумын иргэн) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Батнайрамдал | -(Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Х.Баатарзориг)-нд үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/230 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ